

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ,  
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2019 ОНЫ ТАЙЛАН

2019.12.13.

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
1	Төсөл хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр,
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Нийслэлийн төсөв
3	Хэрэгжүүлэгч байгууллага /хэрэгжих нийт хугацаа/	Нийслэлийн Засаг даргын тамгын газар Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар /1 жил/
4	Хөтөлбөрийн зорилт	
	<p><b>Үндэсний хөтөлбөрийн заалт: 4.1.1. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх</b></p> <p><b>Үндэсний хөтөлбөрийн заалт: 4.1.2. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, хүртээмж, үр ашгийг нэмэгдүүлэх</b></p> <p><b>Үндэсний хөтөлбөрийн заалт: 4.1.3. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх</b></p> <p><b>Үндэсний хөтөлбөрийн заалт: 4.1.4 Худалдан авах ажиллагааны хяналт, хариуцлага, үр ашгийг нэмэгдүүлэх</b></p> <p><b>Үндэсний хөтөлбөрийн заалт: 4.1.7. Иргэний</b></p>	<p><b>2019 ОНЫ ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ</b></p> <p><b>Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх</b></p> <p>Газрын даргын 2019 оны А/48 дугаар тушаалаар Ажлын хэсэг томилж, ажлын байранд дүн шинжилгээ хийсэн. Нийт албан хаагчдаас судалгаа авч, ажлын байранд заасан чиг үүргийг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай чадавхийн түвшин, гүйцэтгэх ажилбарууд болон ажлын орчин нөхцлийг тодорхойлж, шинжилгээ хийсний дүнд албан тушаалын жагсаалтыг 2019 оны А/99 дүгээр тушаалаар шинэчлэн баталж, уг жагсаалтын дагуу албан хаагчдын “Албан тушаалын тодорхойлолт”-ыг боловсруулах талаар Төрийн албаны зөвлөлийн ахлах референт н.Энхцэцэгээс зөвлөмж авч, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулах ажил хийгдэж байна.</p> <p>Авлигын эсрэг хуульд заасан хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах шаардлагатай орлогч дарга, хэлтсийн дарга нар, ахлах мэргэжилтнүүдийн хөрөнгө орлогын мэдүүлгийг 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргуулж, тайланг Нийслэлийн Засаг Даргын Тамгын газарт хүргүүлсэн.</p> <p>Мөн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн албан хаагчдын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж хянуулсны дагуу албан тушаалд томилж, томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулсан.</p> <p>Газрын даргын 2019 оны А/80 дугаар тушаалаар “Ес зүйн</p>

<p><b>нийгмийн байгууллагын идэвх санаачилга, оролцоог дэмжих Үндэсний хөтөлбөрийн заалт: 4.1.10. Авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх</b></p>	<p>дүрэм” болон “Албан хаагчийн ёс зүйн гэрээний загвар”-ыг тус тус баталж, албан хаагчидтай гэрээ байгуулсан.</p> <p>“Ёс зүйн зөвлөл”-ийн 2019 оны ажлын төлөвлөгөөг газрын даргын 2019 оны А/26 дугаар тушаалаар баталж, 5 дугаар сард “Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлага, зан үйл” сэдэвт сургалтыг нийт албан хаагчдад зохион байгуулсан.</p> <p>09 дүгээр сард албан хаагчдын хувь хүний онцлог, давуу талыг ойлгох, албан хаагчийн зан, хандлагыг дээшлүүлэх чиглэлээр “Ёс зүйн 7 хоног” аян зохион байгуулсан.</p> <p>Манлайлал сэдэвт 2 өдрийн сургалтыг НЗДТГ-ын Сургалтын танхимын ажилтан Шинэцэцэгтэй хамтран нийт албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан.</p> <p><b>Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх</b></p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>/-ээр дамжуулан 2019 онд нийслэлд хэрэгжих 506,2 тэрбум төгрөгийн 290 багц төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд олон нийтэд мэдээлсэн. Үүнээс тус газарт эрх шилжин ирсэн 225.7 тэрбум төгрөгийн /задарснаар/ 252 төсөл, арга хэмжээг 100 хувь цахим системээр зохион байгуулаад байна.</p> <p>Мөн гэрээ байгуулагдсан 231 ажлын үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>), тус газрын цахим хуудас <a href="http://www.ub-procurement.mn">www.ub-procurement.mn</a>, <a href="http://www.shilendans.gov.mn">http://www.shilendans.gov.mn</a> цахим системд тус тус нийтэлсэн.</p> <p>Байгууллагын <a href="http://www.ub-procurement.mn">www.ub-procurement.mn</a> цахим хуудасны Хууль, эрх зүй булангаар дамжуулан тендер шалгаруулалттай холбоотой Сангийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэр, Нийслэлийн Засаг даргын худалдан авах ажиллагааны эрх шилжүүлсэн захирамж, газрын даргын тушаалыг тухай бүрт шинэчлэн ил тод мэдээлсэн.</p> <p>Газрын мэдээллийн самбарын Хууль эрх зүй буланд шинээр батлагдсан хууль, дүрэм журмыг 14 хоног тутам шинэчлэн байршуулж, тендерт оролцогч аж ахуйн нэгжийг мэдээллээр хангаж байна.</p> <p>Тендерт оролцогчид дотоодын давуу эрх тооцох аргачлалыг сурталчилсан брошурыг бэлдэж, байгууллагын цахим хуудаст нийтэлсэн.</p> <p>Газрын даргын 160 А тушаал батлагдсанаас 56 А тушаалыг кодификаци хийж Нийслэлийн эрх зүйн</p>
--	---

		<p>мэдээллийн нэгдсэн систем <a href="http://www.ublegal.mn">www.ublegal.mn</a> цахим хуудаст ажлын 3 хоногийн дотор байршуулж ажилласан.</p> <p>2019 онд нийслэлийн төсвөөс тус байгууллагад 571.3 сая төгрөгийн санхүүжилт хийгдэхээр, 25.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр төсөвлөгдсөн. Тайлант хугацаанд 482.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, 465.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан бөгөөд 2.5 сая төгрөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй, 14.4 сая төгрөгийн төсвийн хэмнэлттэй ажилласан байна. Мөн тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 25.0 сая төгрөг төсөвсөлснөөс 25.5 сая төгрөгийн орлого орж 0.5 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөг давж биелүүлсэн үзүүлэлттэй байна.</p> <p>Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ажлын хүрээнд өмнөх оны төсвийн гүйцэтгэл, сар улирлын гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, хагас жилийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, тендер шалгаруулалтын талаарх мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл, орлого зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> мэдээллийн нэгдсэн системд татаж авах, хэвлэх боломжтойгоор, тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийн хамт байршуулан мэдээлж байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргаас тус газарт эрх шилжүүлэн зохион байгуулсан 168 төсөл, арга хэмжээний ажлын үр дүн, холбогдох мэдээлэлийг “shilendans.gov.mn” системд байршуулсан.</p> <p>Хүний нөөцтэй холбогдол бүхий мэдээллийг сарын 01-03-ны өдрүүдэд цаг хугацааны хоцрогдолгүй “shilendans.gov.mn” системд байршуулсан.</p> <p>Мөн тус газарт үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдон ажиллаж буй 95 үнэлгээний хорооны 424 төлөөллийг мэдэгдлийг “shilendans.gov.mn” системд байршуулж, мэдүүлсэн.</p> <p>Нийт 128 төсөл арга хэмжээний хэмжээний 640 ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг “shilendans.gov.mn” системд байршуулсан.</p> <p><b>Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх</b></p>
--	--	---

		<p>Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, аливаа өр авлага үүсгэхгүй хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллаж байна</p> <p>Байгууллагын санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, УИХ, Сангийн сайдын баталсан холбогдох заавар, журмыг мөрдөж ажиллаж байна. Мөн Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын олон улсын стандарт болон Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журамд нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан батлуулж мөрдөн ажиллаж байна.</p> <p>2018 оны санхүүгийн аудитын хяналт шалгалтаар зөрчилгүй санал дүгнэлт авсан. 2019 оны 01-09 дүгээр сарын баримтуудыг завсрын аудитаар хянуулан, зөвлөмжийг 4-р улирлын санхүүгийн тайланд тусган Аудитын байгууллагад хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна.</p> <p><b>Худалдан авах ажиллагааны үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх</b></p> <p>НИТХ-ын 2018 оны “Нийслэлийн 2019 оны төсөв батлах тухай” 20/17 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн төсвийн хөрөнгө, Нийслэлийн Замын сангийн хөрөнгө, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих нийт 506,186.2 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 290 багц хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний “Худалдан авах ажиллагааны 2019 оны ерөнхий төлөвлөгөө”-г төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>, байгууллагын цахим хуудас <a href="http://www.ub-procurement.mn">www.ub-procurement.mn</a>, Нийслэлийн <a href="http://www.ulaanbaatar.mn">www.ulaanbaatar.mn</a> цахим хуудас болон “Засгийн газрын мэдээ” сонины 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн дугаарт нийтлүүлж, олон нийтэд мэдээлсэн.</p> <p>НЗД-ын 185 дугаар захирамжийг үндэслэн Сангийн яаманд 63 удаа хүсэлт гаргаж, дээрх төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан 861 төсөл, арга хэмжээг системд бүртгэж, худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрх шилжүүлэх ажлыг 564 удаа хийж гүйцэтгэн цахим системээр тендер зохион байгуулах боломж нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.</p>
--	--	--

Тус газарт эрх шилжиж ирсэн нийт 265 ажлаас 262 ажлын худалдан авах ажиллагааг 100 хувь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр зохион байгуулж, байгууллагын цахим хуудас ([www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn))-т холбогдох мэдээллийг тухай бүр нийтэлж байна.



Мөн тендерийн урилгыг өдөр тутмын “Засгийн газрын мэдээ” сонинд 149 удаа, “Монголын мэдээ” сонинд 63 удаа, “Зууны мэдээ” сонинд 26 удаа тус тус нийтэлж, тендерт оролцохыг сонирхогч этгээдэд ил тод, нээлттэй зарлан мэдээлж байна.

Мөн 2019 онд зарлагдсан төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын явц, тодруулга, тендерийн нээлтийн тухай мэдээллийг тухайн өдөрт нь багтаан олон нийтэд нээлттэй мэдээлж ажилласан.

Нийслэлийн нутгийн захиргааны 31 байгууллагын төлөөлөлд 693 удаа утсаар болон teamviewer програмын тусламжтайгаар [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө үүсгэж, бүртгэх, тендерийн урилга зарлах, нээлт хийхтэй холбоотой зааварчилгаа өгч, дэмжлэг үзүүлсэн.

Засгийн газрын Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалтыг хангах, худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах тухай 3 удаагийн зөвлөмжийг Нийслэлийн нутгийн захиргааны 89 байгууллагад 2019 оны 01/213, 01/451 болон 03/566 дугаартай албан бичгээр хүргүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан.

Нийслэлийн Засаг дарга үүрэг болгосны дагуу тендерийн ил тод, нээлттэй байдлыг олон нийтэд сурталчлах, тендерийн нээлтийг хэвлэл мэдээллийн байгууллага, иргэн олон нийт, тендерт оролцогчийн оролцоотой зохион байгуулах ажлыг 5 дугаар сараас эхлүүлсэн. Уг арга хэмжээнд хэвлэл мэдээллийн байгууллагын 10 гаруй төлөөлөл, 214 аж ахуйн нэгж, иргэний төлөөлөл оролцсон. Мөн долоо хоног бүр тендерийн нээлтийг LIVE хэлбэрээр хийж youtube мэдээллийн сүлжээ, [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn) цахим хуудаст байршуулж хэвшсэн.

Энэхүү ажлын хүрээнд нийт 32 төсөл, арга хэмжээний тендерийн нээлтийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын хурлын танхимаас олон нийтийн

		<p>сүлжээ (<a href="http://www.facebook.com">www.facebook.com</a>)-ээр шууд дамжуулан тендерт оролцогчид болон иргэд, олон нийтэд нээлттэй хэлбэрээр мэдээлсэн.</p> <p>Мөн Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тогтоолоор батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ын дагуу 2019 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс зарлагдсан нийт 126 удаагийн тендер шалгаруулалтын материалыг худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан тухайн тендерт оролцогчдод ил болгож, тэгш өрсөлдөөнийг дэмжин ажиллаж байна.</p> <p>“Ил тод худалдан авах ажиллагаа 2019” арга хэмжээг Нийслэлийн иргэний танхимд 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулж 131 аж ахуйн нэгж, иргэн оролцуулсан. Уг арга хэмжээний үеэр 2 төсөл, арга хэмжээний тендерийн нээлтийг олон нийтэд, нээлттэй мэдээлсэн бөгөөд MNB TV-ийн "Зочны цаг" хөтөлбөр, MNC TV-ийн шууд ярилцлага, UBS TV-ийн өдрийн мэдээ, <a href="http://www.ulaanbaatar.mn">www.ulaanbaatar.mn</a>, <a href="http://www.zasag.mn">www.zasag.mn</a>, <a href="http://www.ulaanbaatar.mn">www.ulaanbaatar.mn</a> цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дарга, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, аж ахуй нэгж байгууллага, иргэний төлөөлөл худалдан авах ажиллагааны талаар ярилцлага мэдээлэл өгч, олон нийтийг мэдээллээр хангасан.</p> <p>Мөн мэргэжлийн байгууллагын албан хаагчид оролцогч иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөлд зөвлөгөө мэдээлэл өгч, худалдан авах ажиллагааны цахим систем болон хууль журмын талаар 5 төрлийн 1020 ширхэг гарын авлаг тарааж, 130 гаруй иргэн, аж ахуй нэгжийн төлөөллөөс санал асуулга авч ажилласан</p> <p>Тендерийн сонгон шалгаруулалттай холбоотой оролцогчоос ирүүлсэн гомдлын дагуу Сангийн яам болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт тус байгууллагаас холбогдох баримт материалыг шуурхай хүргүүлж хэвшсэн.</p> <p><b>Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй ажилтай холбоотой Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт 6, Сангийн яаманд 32 гомдол, Шүүхэд 7 гомдол гарсныг судлан үзэж, өөрсдөөс шалтгаалсан зөрчлийг давтан гаргахгүй байхад чиглэсэн арга хэмжээг авч ажиллаж байна.</b></p> <p><b>Нийслэлийн Засаг даргын 2019 оны 08 дугаар</b></p>
--	--	--

		<p>сарын 26-ны өдрийн №22 дугаар удирдамжаар Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын үндсэн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх ажлын баг бүрэлдэхүүн ирсэн. Тус баг 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2018 оны 12 дугаар 31-ний өдрийг дуусталх хугацааны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.</p> <p>Байгууллагад ирүүлж буй өргөдөл гомдол, хүсэлтийг ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэх зорилт тавьсан ба тайлант хугацаанд 54 өргөдөл, хүсэлт ирснийг дунджаар ажлын 5 хоног 17 цаг 48 минутад хуулийн дагуу бүрэн шийдвэрлэсэн.</p> <p>Сангийн сайдаас ирүүлсэн 2019 оны 6-1/5422 дугаар албан бичгийн дагуу тус газар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, 14.1.6, 14.1.7 дахь заалтуудад заасан тендер шалгаруулалт, гэрээний хэрэгжилттэй холбоотойгоор үүссэн зөрчлийн талаарх мэдээлэл, нотлох баримт ирүүлэх талаар Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадууд, Дүүргийн Засаг даргын тамгын газрууд, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад 2019 оны 02/1287, 02/1288, 02/1289, 02/1291 дүгээр албан бичгүүдээр мэдэгдсэн. Энэ дагуу 35 байгууллага хариу мэдээллийг албан бичгээр ирүүлснийг нэгтгэж Сангийн яамд хүргүүлсэн. <b>Төрийн худалдан авах ажиллагааны <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системийг нийслэлийн хэмжээнд бүрэн нэвтрүүлэх ажлын хүрээнд:</b></p> <p>Нийслэлийн хэмжээнд улс, нийслэл, орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээр нийт 683.2 тэрбум төгрөгийн 2176 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас 655.5 тэрбум төгрөгийн 2109 төсөл, арга хэмжээний тендер зарлагдсан. Үүнээс 94 хувь буюу 597.7 тэрбум төгрөгийн 1838 төсөл, арга хэмжээг цахим системээр зохион байгуулж, хэрэгжилтийн хувьд өнгөрсөн оныхоос 44 хувиар өссөн дүнтэй байна. Нийт ажлын 7,2 хувь буюу 17,1 тэрбум төгрөгийн 153 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа нь төрийн нууцад хамаарах, шууд худалдан авалтын журмаар зохион байгуулагдсан тул цахим системээр зохион байгуулах боломжгүй</p> <p>2019.04.22, 2019.05.01 болон 2019.05.10-ны өдрүүдэд нутгийн захиргааны 43 байгууллагын 50 албан хаагчдад “Цахим системийн ашиглалт”, “Худалдан авах</p>
--	--	--

	<p>ажиллагааны тайлагналт” сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан.</p> <p>2019.05.30-ны өдөр 9 дүүргийн худалдан авах ажиллагааны албадтай уулзалт зохион байгуулж, улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр зохион байгуулагдаж буй төсөл, арга хэмжээний удаашралтай байгаа ажлуудыг эрчимжүүлэх талаар санал солилцож, туршлага хуваалцаж ажилласан.<b>Худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулах ажлын хүрээнд</b> Нийслэлийн хэмжээнд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 696,9 тэрбум төгрөгийн 2101 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас 572.9 тэрбум төгрөгийн 1866 төсөл, арга хэмжээний тендер зарлагдсан. Үүнээс 91,8 хувь буюу 548.3 тэрбум төгрөгийн 1744 төсөл, арга хэмжээг цахим системээр зохион байгуулсан Худалдан авах ажиллагааны ил тод нээлттэй байдлыг дээшлүүлэх ажлын хүрээнд:</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/762 дугаар захирамжаар Улс, нийслэлийн төсөв болон бусад эх үүсвэрээр нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлт, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмжийг үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах, гурвалсан гэрээний загварыг өөрчилж, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гэрээний маягт ашиглаж ажиллахыг даалгасаны дагуу биелэлтийг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p><b>Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах</b></p> <p>Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээ эзэмшсэн үнэлгээний хороонд орж ажиллах хүсэлтэй иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 04/82 тоот албан бичгийг НИТХ-ын ажлын алба, ТӨБЗГ, сургалтын байгууллагуудад хүргүүлэн байгууллагын цахим хуудас /ub-procurement.mn/, байгууллагын facebook page хуудас, өдөр тутмын хэвлэлд иргэд бүртгэж буй зарлал нийтлүүлэн АЗ гэрчилгээ эзэмшсэн иргэдийн мэдээллийн дагуу иргэдтэй холбогдон зөвшилцсөний үндсэн дээр</p>
--	--



		<p>100 иргэний мэдээллийг Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлж, НИТХ-ын 2019 оны 08 дугаар сарын 02-ны 127 дугаар тогтоолоор иргэдийн жагсаалтыг батлуулсан.</p> <p>Сангийн сайдын баталсан журмын дагуу үнэлгээний хороонд иргэний төлөөллөөр ажилласан цагийг үндэслэн ТҮ-7 нэгдүгээр шатлалын нэг цагийн цалинтай тэнцэх хэмжээний буюу цагт 3547 төгрөгийн урамшуулал хөлс олгож хэвшсэн.</p> <p>Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажилласан 19 иргэний төлөөлөлд 2019 оны 1 дүгээр сараас 12 дугаар сарын хугацаанд өссөн дүнгээр 1405137 төгрөгийн урамшуулал олгосон.</p> <p><b>Худалдан авах ажиллагаан дахь нууцлалыг сайжруулах, хариуцлагыг өндөржүүлэх, хар жагсаалтад байгаа хуулийн этгээдийн цахим сонгон шалгаруулалтад оролцох боломжийг хязгаарлах</b></p> <p>-Тендерийг нийтийн өмнө нээсний дараа шалгарсан тендерт оролцогчтой гэрээ байгуулах хүртэл тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх болон гэрээ байгуулах эрх олгох тухай дүгнэлттэй холбоотой аливаа мэдээллийг энэ үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй этгээдэд задруулахгүй байх зарчмын дагуу худалдан авах ажиллагаан дахь нууцлалыг хангаж ажиллаж байна.</p> <p>- Тендерийн баримт бичгийн аюулгүй байдлыг хангаж 2015, 2016, 2017, 2018, 2019 оны байдлаар лац ашиглан, бүртгэлийн дэвтрийг хөтөлж ажилласан.</p> <p><b>Иргэд олон нийтийн оролцоо хяналтыг нэмэгдүүлэх чиглэлээр:</b></p> <p>"Эх оронч худалдан авалтын жил"-ийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажил хариуцсан нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 арга хэмжээг тусган баталж, хэрэгжилтийг 100 хувь хангаж ажилласан. Үүнд, Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад заасан бараанаас 11 багц ажилд 1.934,2 сая төгрөгийн өртөг бүхий 74 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн худалдан авсан байна. Нийт 252 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт дотоодын давуу эрхийн зөрүү тооцохоор тусгасан. Үүнээс 32 оролцогч давуу эрх тооцуулахаар шаардлагад нийцсэн баримт материал ирүүлсэн ба 12 оролцогч</p>
--	--	--

		<p>дотоодын давуу эрх тооцуулан тендерт шалгараад байна.</p> <p>Дотоодын үйлдвэрлэлээс бараа худалдан авсан тухай тайланг хагас жилийн байдлаар Үндэсний аж үйлдвэрийн зөвлөлд 2019 оны 01/585 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж урсгал зардлаар худалдан авах барааг дотоодын үйлдвэрлэлээс сонгон авах тухай зөвлөмжийг 2019 оны 01/213 дугаар албан бичгээр нийслэлийн нутгийн захиргааны 68 байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>“Эх оронч худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл 2019” үзэсгэлэнд 2019.04.02-03-ны өдрүүдэд нийслэлийн нутгийн захиргааны 9 байгууллага нэгдэн оролцож, 150 гаруй үйлдвэрлэгчдэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах боломжтой барааны жагсаалт, дотоодын давуу эрхийн зөрүү тооцох аргачлал, цахим системийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч, 125 дотоодын үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагаас санал асуулга авсан.</p> <p>2019 оны 04 дүгээр сард зохион байгуулсан “Эх оронч худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл 2019” үзэсгэлэн, “Ил тод худалдан авах ажиллагаа 2019” арга хэмжээ, 2019 оны 11 дүгээр сард зохион байгуулсан “Худалдан авах ажиллагааг хэрхэн зохион байгуулах-Тендерт хэрхэн амжилттай оролцох вэ” сэдэвт сургалтын үеэр тус тус худалдан авах ажиллагааны ил тод байдлын хэрэгжилтийг хэрхэн үнэлж дүгнэж байгаа талаар 125 дотоодын үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, 195 иргэн, аж ахуй нэгжээс судалгаа авч, үр дүнг нэгтгэж ажилласан. Санал асуулгын дагуу цаашид авч хэрэгжүүлэх, анхаарах асуудлыг 2020 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллахаар бэлтгэж байна.</p>
--	--	---

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

С. ОЮУНЧИМЭГ